



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2017 ОН



Өлгий хот 2018 он

Танилцуулгыг хянан, тохиосон:

Н.Ерлан

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Х.Аленхан

Санал хүсэлт байвал доорх

хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

E-mail: bayan-ulgii@nso.mn, Alenkhan@nso.mn

Утас: 70422432 ,70422322

Интернет хаяг: //www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/

АГУУЛГА

I. Оршил	4
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	5
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	8
II. Мал аж ахуй	
II.2.1 Малтай өрх, малчин өрх, малчдын тоо	9
II.2.2 Малчдын соёл, ахуйн үзүүлэлт	12
II.2.3 Малын тоо	14
II.2.4 Малын сүргийн бүтэц	15
II.2.5 Малын хэрэглээний зарлага	21
II.2.6 Төл бойжилт	23
II.2.7 Том малын зүй бус хорогдол	26
II.2.8 Иргэдийн хувийн малын бүлэглэлт	29
II.2.9 Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан	31
II.2.10 Малжуулалтын талаар авсан арга хэмжээ	32
II.2.11 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	33
II.2.12 Тэжээвэр амьтад	34
III. Газар тариалан	
III.1 Тариалсан талбай	36
III.2 Хураасан ургац	37
III.3 ХАА-н эдэлбэр газар	38
IV. Дүгнэлт	39

_____ о О о _____

ОРШИЛ

ХАА-н салбар нь манай улс орны эдийн засгийн баталгаа болж байдаг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2017 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2017 оны сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2017 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна шинээр гаргасан худаг, уст цэг, малжуулалтын талаарх мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр – 1 бод

1 тэмээ - 1.5 бод

6 хонь - 1 бод

8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1 үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45,

Хуц, ухна - 25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл-0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22, Үр

тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25 гэсэн

итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

· Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.

2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.

3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.


ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2017 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр 2 сая 226 мянга 149 толгой мал тоологдсон өнгөрсөн оноос 58798 толгойгоор нэмэгдэж 2.7 хувиар өссөн. Том малын зүй бус хорогдол 17800 толгой болж өмнөх оны мөн үеийнхээс 13053 толгой буюу 42.3 хувиар бага байна. Оны эхний хээлтэгч малын 98.7 хувь нь төллөж 748279 төл бойжиж, төл бойжилт 82.9 хувьтай гарсан. Өнгөрсөн жилийн цаг агаарын байдлаас шалтгаалж малын тоо өсөж, мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн өссөн нь хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн энэхүү өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 35.3 хувийг эзэлж, 116.2 тэрбум төгрөг хүрч, өмнөх оноос 3.6 хувиар буурсан байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ, ХЭМЖЭЭ

	2013	2014	2015	2016	2017	/тэрбум.төг/	
						2017/2016	
						%	Зөрүү
Бүгд	232.1	289.7	311.0	307.1	329.5	107.3	22.5
ХАА-н салбар	94.1	113.9	126.5	119.5	116.2	97.2	-3.3
ДНБ-д эзлэх хувь	40.5	39.3	40.7	38.9	35.3	90.7	-3.6

ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ




Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар аймгийн ДНБ-ий 35-45 орчим хувийг үйлдвэрлэж, 2007 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын

ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өсөж байна.

Улсын хэмжээнд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах хандлагатай байна. ХАА-н салбар нь 2001 онд ДНБ-ний 24.9 хувийг эзэлж байсан бол 2015 онд 15 хувийг эзэлж байна. Баруун бүсийн дүнд эзлэх хувь 2001-2007 онд өсөж 74.2-т хүрч 2018-2017 онд 35.3 хувь болон буурчээ. Баян-Өлгий аймгийн хувьд хандлага нь баруун бүсийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 2004 онд 67.2 хувьд хүрч, 2017 онд 35.5 хувь болж буурлаа.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

/ 2017 □□

Сумын нэр	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	16-с дээш насны малчдын тоо	Үүнээс:			Нийт малчдаас эмэгтэй
				15-34 настай	35-59 эр, 35-54 эм настай	Эр 60, эм 55-с дээш настай	
Алтай	1000	702	1224	473	609	142	522
Алтанцөгц	683	383	692	243	374	75	285
Баяннуур	1028	454	725	187	461	77	279
Бугат	796	427	720	261	408	51	297
Булган	1169	782	1617	644	820	153	736
Буянт	660	439	774	272	404	98	344
Дэлүүн	1423	1036	2047	785	1103	159	937
Ногооннуур	1529	904	1390	522	722	146	473
Сагсай	1135	793	1454	577	702	175	623
Толбо	870	589	1206	564	498	144	468
Улаанхус	1557	1207	2385	831	1248	306	1098
Цэнгэл	1720	1469	2843	1123	1404	316	1244
Өлгий	1406	76	123	33	70	20	44
Дүн	14976	9261	17200	6515	8823	1862	7350


Аймгийн хэмжээгээр 2017 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 14976 өрх тоологдсон байна. Үүний 61.8 хувь буюу 9261 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 38.2 хувь буюу 5715 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2017 онд дүнгээр 17200 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 37.8 хувь нь 15-34 настай, 51.3 хувь нь 35-59 насны, 10.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 15-34 болон 35-59 насны малчдын эзлэх хувийн жин буурч, 2017 онд 60-с дээш насны буюу тэтгэврийн насны малчдын тоо 16.4 хувь буюу 262 хүнээр нэмэгджээ.

2017 онд малчин өрхийн тоо 2016 онтой харьцуулахад 4.2 хувь буюу 373 өрхөөр нэмэгджээ .

Малчин өрхийн тоо Улаанхус, Буянт, Бугат, Баянуур, Толбо, сумдад буурч, малтай өрхийн тоо Алтай, Сагсай, Толбо, Улаанхус, цэнгэл сумуудад мөн буурсан байна. Малтай өрхийн тоо сүүлийн 4 жилийн үзүүлэлтээс харахад өмнөх жилүүдэдээс бол 2017-2016 онд бага зэрэг өсөж, байгаа нь харагдана.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР



МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР

	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Малтай өрх	16298	16416	15499	15194	15126	14998	14930	13862
Малчин өрх	11200	11511	10961	11078	11102	9723	10380	9436
Малчдын тоо	23513	24889	23234	23071	23682	22886	21141	18685
Үүнээс: 16-34 насны	13805	14196	13428	13241	13114	12377	10589	9528
35-59 насны	8035	8402	8096	8548	9140	8795	8189	7195
Тэтгэврийн насны	1673	2291	1710	1282	1428	1714	2363	1962

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	/2017/ /2016/
Малтай өрх	13862	13502	14104	14636	14608	14961	14976	104.0
Малчин өрх	9436	8383	8392	8921	8872	8888	9261	104.2
Малчдын тоо	18685	17808	17723	18302	18398	18411	17200	93.4
Үүнээс: 16-34 насны	9037	8644	8120	7693	7396	6927	6515	94.1
35-59 насны	7853	7902	8249	9117	9433	9884	8823	89.3
Тэтгэврийн насны	2005	1262	1354	1492	1569	1600	1862	116.4

МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХИЙН ТООГООР, ЖИЛЭЭР

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Цахилгаантай өрх	9038	8947	8362	6635	7595	7289	5928	5978
Телевизортой	8409	8407	8300	4745	4453	4355	3401	3554
Автомашинтай	2780	2663	2693	2680	2997	3542	5359	2301
Мотоциклтэй	2697	3585	3594	3187	3245	3475	2775	1730
Худагтай	1198	1215	1215	2116	3029	2974	3691	5240

2017 оны тооллогоор нийт малчин өрхийн 64.5 хувь нь цахилгааны эхүүсгүүртэй, 38.4 хувь нь телевизортой, 24.8 хувь нь авто машинтай, 18.7 хувь нь мотоциклтэй, 56.6 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хагах арга хэмжээг авч байсны үр дүнд цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2008 онд 8.8 мянган өрх цахилгааны эх үүсгүүртэй байсан бол 2009 онд 9.2 мянга болж 4.0 хувь буюу 353 өрхөөр нэмэгдсэн байна. Харин 2013 онд энэ үзүүлэлт 6.6 мянга болж 27.8 хувиар багассан нь сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар 2017 онд цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 2016 оноос 50 өрхөөр нэмэгдсэн байна. 2017 онд мотоциклтэй өрхийн тоо 1045 өрхөөр буурч, харин авто машинтай өрхийн тоо 28 өрхөөр, худагтай өрхийн тоо 1549 өрхөөр, телевизортой өрхийн тоо 153 өрхөөр тус тус нэмэгдэж байна. Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 95.8 хувь нь нарны, үлдсэн 4.2 хувийг цахилгааны төвлөрсөн системд холбогдсон өрх эзэлж байна.

МАЛЧДЫН АХУЙ СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХӨӨР /мян.өрх/



МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

/өрхийн тоогоор, 2017/

Сумын нэр	Баг хорооны тоо	Цахилгаан эх үүсвэртэй өрх	Үүнээс		Радиотой өрх	Оёдлын машинтай өрх	Телевизортэй өрх	Малын хашаатай өрх
			Нарны	Салхины				
Алтай	5	458	458		171	222	244	891
Алтанцөгц	4	305	292		232	196	206	593
Баяннуур	5	122	121		49	56	75	988
Бугат	4	151	150		99	100	46	754
Булган	7	716	637		107	374	486	806
Буянт	4	219	219		139	139	175	504
Дэлүүн	10	887	873	1	543	530	599	1230
Ногооннуур	9	370	369	1	159	90	105	1312
Сагсай	6	669	669	1	387	338	382	1037
Толбо	6	231	849		146	108	142	699
Улаанхус	8	928	849	1	698	621	587	1261
Цэнгэл	9	1029	889		252	229	568	1620
Өлгий	13	74	1		1	1	1	1566
Дүн	90	6159	6376	4	2983	3004	3616	13261

Сумын нэр	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Гар утастай		Хийсэн эсгий (м)
		Өрхийн тоо	Машины тоо	Өрхийн тоо	Мотоциклийн тоо	Өрхийн тоо	Гар утасны тоо	
Алтай	275	245	307	212	212	675	951	1438
Алтанцөгц	165	247	330	187	187	383	683	78
Баяннуур	903	226	265	230	230	454	405	612
Бугат	608	278	370	145	149	424	496	581
Булган	146	386	418	261	265	482	680	358
Буянт	49	268	305	181	181	420	630	119
Дэлүүн	6	830	863	241	241	860	614	825
Ногооннуур	708	731	581	220	220	829	279	157
Сагсай	391	280	460	172	172	693	840	978
Толбо	258	421	448	176	176	586	843	992
Улаанхус	439	742	799	494	496	740	940	1059
Цэнгэл	45	440	428	246	246	862	986	683
Өлгий	1247	293	321	12	12	76	402	0
Дүн	5240	5387	5895	2777	2787	7484	8749	7880

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2226.1 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 2.7 хувь буюу 58798 толгойгоор өслөө. Үүнд тэмээ 346 толгой, адуу 7619 толгой, үхэр 5402 толгой, хонь 57462 толгой, толгойгоор тус тус нэмэгдэж, ямаа -12093 толгойгоор буурсан. Өнгөрсөн онтой харьцуулахад 2017 онд бүх сумдад малын тоо 19,4 хувь буюу 8931 толгойгоор өссөн байна.

2017 онд нийт 58,2 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 37,4 хувийг эзэлж байна.


МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
						%	Зөрүү
Бодоор /мян.тол/	377.2	446,3	487,6	528,6	548.6	108.4	41.0
Толгойн тоо	1604080	1883610	2021046	2167351	2226149	102.7	58798
Тэмээ	4348,0	4671.0	4717	4933	5279	107.0	346
Адуу	58440	69562	77291	85779	93402	108.9	7623
Үхэр	105079	127443	144761	155615	161025	103.5	5410
Хонь	662827	799861	850620	937710	995222	106.1	57512
Ямаа	773386	882073	943657	983314	971221	98.8	-12093

МАЛЫН ТОО, СУМААР

	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
						%	зөрүү
Алтай	125427	145454	154484	151 932	160 144	105.4	8212
Алтанцөгц	72052	87619	95219	106 428	115 808	108.8	9380
Баяннуур	116784	143819	151434	152 678	167 787	109.9	15109
Бугат	75770	86670	94209	110 631	119 155	107.7	8524
Булган	90810	105078	120785	135 457	129 578	95.7	-5879
Буянт	104146	120243	130226	143 641	149 988	104.4	6347
Дэлүүн	207784	236491	262116	283 529	267 759	94.4	-15770
Ногооннуур	146023	173671	183847	206 398	225 043	109.0	18645
Сагсай	112657	130645	146003	158 751	167 075	105.2	8324
Толбо	134027	159064	167408	177 861	183 896	103.4	6035
Улаанхус	158402	186770	196223	207 459	215 179	103.7	7720
Цэнгэл	236422	281880	293785	305 120	298 012	97.7	-7108
Өлгий	23776	26206	25307	27 466	26 725	97.3	-741
Дүн	1604080	1883610	2021046	2167351	2 226 149	102.7	58798

МАЛЫН ТОО



2017 онд улсын хэмжээнд нийт 66218.9 мянган толгой мал тоологдсоны 3.6 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс, тэмээ 1.2 хувь, адуу 2.4 хувь, үхэр 3.7 хувь, хонь 3.3 хувь, ямаа 3.6 хувийг тус тус эзэлнэ

	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо /Улсын дүнгээр/			Улсын дүнд эзлэх %		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
Бодоор	487,6	528,9	548.3	14729,3	15904,8	17053.3	3.2	3.3	3,3
Толгойн тоо	2021,0	2167,4	2226.1	55957,6	61542,1	66215.8	3.6	3.6	3,6
Тэмээ	4.7	4,9	5.2	367,9	401,3	434.1	1.3	1.3	1,2
Адуу	77,3	85,8	93.4	3294,6	3634,9	3939.4	2.2	2.3	2,3
Үхэр	144,8	155.6	161	3779,5	4080,3	4388.2	3.6	3.7	3,8
Хонь	850,6	937,8	995.2	24933,4	27853,4	30108.0	3.3	3.4	3,3
Ямаа	943,6	983,3	971.2	23582,2	25572,2	27346.1	4.0	4.0	3,9

ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ


	2000	2009	2010	2011	2012	2013	2014
Малтай өрхийн тоо	15402	14930	13862	13858	13858	14104	14636
Бодоор	340924	293285	253951	293760	293760	376132	446352
Толгойн тоо	1299891	1296751	1122835	1298851	1298851	1600067	1878450
Тэмээ	6943	3863	3764	3989	3989	4346	4669
Адуу	67905	50453	43077	48160	48160	57976	68863
Үхэр	95975	70671	66019	80785	80785	105023	127306
Хонь	611910	521362	457245	504472	504472	660576	796869
Ямаа	517158	650402	552730	661445	661445	772146	880743

	2015	2016	2017	2017/2000		2017/2016	
				%	Өсөлт(-,+)	%	Өсөлт(-,+)
Малтай өрхийн тоо	14608	15192	14976	97.2	-426	98.6	-216
Бодоор	487618	528884	548372	160.8	207448	103.7	19488
Толгойн тоо	2016300	2167413	2226149	171.3	926258	102.7	58736
Тэмээ	4716	4933	5279	76.0	-1664	107.0	346
Адуу	76593	85783	93402	137.5	25497	108.9	7619
Үхэр	144650	155623	161025	167.8	65050	103.5	5402
Хонь	847952	937760	995222	162.6	383312	106.1	57462
Ямаа	942389	983314	971221	187.8	454063	98.8	-12093

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР

2017 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 44.7 хувийг хонь, 43.6 хувийг ямаа, 7.2 хувийг үхэр, 4.2 хувийг адуу, 0.3 хувийг тэмээний өсөлт хангасан байна.

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР




Нийт сүргийн 1980 онд 26.8 хувийг ямаа, 59.0 хувийг хонь, 7.5 хувийг үхэр, 5.7 хувийг адуу, 1.0 хувийг тэмээ эзэлж байсан бол 2017 онд 44.7 хувийг хонь, 43.6 хувийг ямаа, 7.2 хувийг үхэр, 4.2 хувийг адуу, 0.3 хувийг тэмээ эзэлж байна.

Сүргийн бүтцэд 1980-2017 онд ямааны эзлэх хувь 16.8 пунктээр өсч, хонины 14.3 пункт, үхэр 0.3 пункт, адууных 1.5 пункт, тэмээ 0.7 пунктээр тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх хонины тоо толгойн хэмжээ өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт мал сүргийн 1991 онд 60.7 хувийг хонь эзэлж байсан бол 1992 оноос буурч 2017 онд 44.7 хувьд хүрчээ. Аймгийн хонины тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь 2001-2017 онд улсын дүнгээс дээгүүр, баруун бүсийн дүнгээс доогуур түвшинд байна.


ХОНИНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгойн хэмжээ 1971-1992 онд тогтвортой байсан бол 1992 оноос огцом өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт сүргийн 1971 онд 26.3 хувийг ямаа эзэлж байсан бол 2017 онд 43.6 хувьд хүрчээ. Ямааны тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь улсын болон баруун бүсийн дүнгээс доогуур түвшинд байна.

Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.

ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	2003	2004	2005	2006	2007	2007	2009	2010
Дүн	596729	584869	585170	637726	681498	664758	602941	519337
Ингэ	2102	1430	1061	1074	1075	1034	1019	1084
Гүү	23145	18455	17213	18356	18909	17335	16172	13788
Үнээ	46458	37417	34016	36785	38853	34579	31193	30544
Эм хонь	291630	252584	251504	271093	283481	269837	243500	213163
Эм ямаа	233394	274983	281376	310418	339180	341973	311057	260758

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016 %
Дүн	566233	626572	685412	797053	835766	914198	915932	100.2
Ингэ	1181	1279	1333	1453	1384	1482	1571	106.0
Гүү	14716	15573	17305	20594	22770	25495	27750	108.8
Үнээ	34998	38083	43803	51023	55884	60269	62282	103.3
Эм хонь	226635	260038	291846	349634	364523	409189	420942	102.9
Эм ямаа	288703	311599	331125	374349	391205	417763	403387	96.6

Хээлтэгч мал нь нийт малын 41.1 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.0 хувь, адуун сүргийн 29.8 хувь, үхэр сүргийн 38.6 хувь, хонин сүргийн 42.3 хувь, ямаан сүргийн 41.5 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50–55 хувь, бог малын хувьд сүргийн 60–65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 35.3 хувь, бог малд 42,1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
						%	Зөрүү
Дүн	48.6	42.7	44.4	42.2	41.1	97.5	-1.0
Ингэ	31.8	30.7	29.6	30.0	30,0	91.0	-3.0
Гүү	33.5	29.6	32.7	29.7	29,8	67.8	-14.2
Үнээ	50.2	41.7	43.9	38.7	38,8	60.5	-25.3
Эм хонь	50.8	44.0	45.6	48.1	43,7	68.9	-19.8
Эх ямаа	47.8	42.8	44.4	44.3	42,5	75.3	-13.9

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

	2000	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Дүн	52085	16609	70210	15000	35586	105416	90454	105922
Ингэ	15	47	26	4	20	9	24	40
Гүү	5569	1972	3428	1294	2046	5459	3046	3669
Үнээ	5859	2207	4242	1263	2472	6499	2282	2514
Эм хонь	11785	3913	11122	4134	9041	17446	8463	11392
Эм ямаа	28857	8470	51392	8305	22007	76003	76639	88307

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016
								%
Дүн	7876	59246	13636	6061	4369	23945	12137	548,0
Ингэ	3	2	6	7	2	8	2	25.0
Гүү	557	362	290	217	162	716	381	53.2
Үнээ	428	5126	505	245	238	734	598	81.5
Эм хонь	1047	7046	2876	1193	1384	3995	1936	48.5
Эм ямаа	5841	46710	9959	4399	2583	18492	9220	49.9

2017 онд оны эхний төллөх насны хээлтэгчийн 1.3 хувь буюу 12137 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2017 оныхоос 11808 толгойгоор буюу 50.7 хувиар буурсан байна.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 45.2 хувь буюу 12137 нь хээл хаясан хээлтэгч, 54.8 хувь буюу 14706 нь сувайрсан хээлтэгч байна.

Сувайрсан малын тоо 2016 оныхоос 18.7 хувь буюу 3389 толгойгоор буурав.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

	2000	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Дүн	22376	15463	26113	13943	13943	24603	30953	48167
Ингэ	220	25	19	17	17	17	3	16
Гүү	3421	2805	2138	1480	1480	1908	2086	2493
Үнээ	4742	3175	3698	2429	2429	4036	3820	4568
Эм хонь	6896	4434	9425	4155	4155	7317	9097	20293
Эм ямаа	7097	5024	10833	5862	5862	11325	15947	20797


	2011	2012	2013	2014	2015	2016	2017	<u>2017/2016</u> %
Дүн	11876	19683	15932	9728	10304	18095	14706	81.3
Ингэ	14	17	39	44	34	85	43	50.6
Гүү	1181	1990	1392	945	817	1255	1450	115.5
Үнээ	2234	2424	2629	1739	1720	2517	2811	111.7
Эм хонь	4027	6644	4996	2763	3454	5946	4647	78.2
Эм ямаа	4420	8608	6876	4237	4279	8292	5755	69.4

ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

	2012	2013	2014	2015	2016	2017	<u>2017</u> 2016%
Буур	86	75	75	77	87	93	106.9
Азарга	1677	1876	1876	2233	2512	2762	110.0
Бух	2192	2298	2298	2874	2992	3031	101.3
Хуц	6610	7243	7243	7695	8401	9002	107.2
Ухна	7566	8143	8143	8386	8955	8488	94.8
Дүн	18131	19635	19635	21265	22947	23376	101.9

2017 онд 23376 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2016 оныхоос 1,9 хувь буюу 429 толгойгоор нэмэгдэв.

НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧИЙНТОО



	Үржлийн норм	2012	2013	2014	2015	2016	2017	<u>2017</u> 2016 %
Ингэ	20-25	12	16	19	18	17	16.0	94.1
Гүү	12-15	10	10	11	10	10	9.0	90.0
Үнээ	35-45	20	20	22	19	20	20.0	100.0
Эм хонь	25-30	43	44	48	47	49	45.0	91.8
Эм ямаа	25-30	43	44	46	47	47	49.0	105.0

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох 45 эм хонь 47,8 хувь, эм ямаа 49 ногдож 52,2 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

	Мянган толгойгоор			2015	Хувиар			Толгой Зөрүү
	2015	2016	2017		2015	2016	2017	
Бүгд	2021.0	2167.3	2226.1	107.3	107.2	102.7	58.8	
Өсвөр насны төл	781.0	752.0	790.5	38.6	38.2	35.5	38.5	
Ажлын ба бэлтгэл насны	383.1	478.2	496.4	18.9	18.7	22.3	18.2	
Хээлтэгч	835.7	914.2	915.9	41.4	42.0	41.1	1.7	
Хээлтүүлэгч	21.2	22.9	23.3	1.1	1.1	1.0	0.4	

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ СУМААР, 2017 ОН

Сумын нэр	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	Хээлтүүлэгч
Алтай	100.0	34.6	23.1	41.1	1.2
Алтанцөгц	100.0	37.7	16.4	44.5	1.5
Баяннуур	100.0	34.2	22.0	43.0	0.8
Бугат	100.0	34.2	23.4	41.2	1.3
Булган	100.0	37.1	20.2	41.6	1.1
Буянт	100.0	29.6	25.5	44.0	0.9
Дэлүүн	100.0	34.4	20.1	44.4	1.1
Ногооннуур	100.0	39.3	18.3	41.6	0.9
Сагсай	100.0	34.9	29.1	35.3	0.8
Толбо	100.0	34.2	18.2	46.5	1.1
Улаанхус	100.0	34.8	30.7	33.5	1.1
Цэнгэл	100.0	38.0	20.2	40.9	0.9
Өлгий	100.0	34.4	17.9	47.1	0.7
Дүн	100.0	35.5	22.3	41.1	1.1

2017 оны байдлаар нийт малын 35.5 хувь буюу 790.5 мянган толгой нь төл өсвөр насны мал, 22.3 хувь буюу 496.4 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 41.1 хувь буюу 915.9 мян.толгой нь хээлтэгч мал, 1.1 хувь буюу 23.4 мян.толгой нь хээлтүүлэгч мал байна. 2017 онд нийт малын тоонд төл өсвөр насны малын эзлэх хувийн жин өмнөх оныхоос 6.7 пунктээр буурч, хээлтүүлэгчийн хувийн жин ижил түвшинд байна. Харин хээлтэгчийн эзлэх хувийн жин 6.4 пунктээр, ажлын ба бэлтгэл насны малын эзлэх хувийн жин 0.2 пунктээр өссөн байна.

Малын хэрэглээний зарлага



2017 онд оны эхний малын 21.2 хувьтай тэнцэх 471727 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2016 оныхоос 79901 толгой буюу 20.4 хувиар нэмэгдсэн байна. Малтай нэг өрх дундажаар 51 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 20 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээндээ зарцуулсан нийт малын 0.2 хувийг тэмээ, 2.2 хувийг адуу, 7.1 хувийг үхэр, 45.6 хувийг хонь, 50.0 хувийг ямаа эзэлнэ.

Хэрэглээнд зарцуулсан малын 90.5 хувийг бог мал, 9.5 хувийг бод мал эзэлнэ.

Сумаар авч үзвэл хэрэглээндээ хамгийн их мал зарцуулсан Дэлүүн сум 85.7 мян.тол. Цэнгэл сум 84.7 мян.тол, Улаанхус сум 45.7 мян.тол, Толбо сум 43.5 мянган толгой мал тус тус зарцуулсан байна.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА


Сумын нэр	2016	2017	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Алтай	29113	23889	32	725	2732	12130	8270
Алтанцөгц	18489	16165	53	326	860	5695	9231
Баяннуур	26011	26102	89	634	997	7037	17345
Бугат	19064	25542	5	446	1288	10517	13286
Булган	26491	20489	48	604	2685	4899	12253
Буянт	23140	29252	23	503	1956	17187	9583
Дэлүүн	51112	85680	36	1808	6012	31423	46401
Ногооннуур	33670	33985	49	696	1654	9583	22003
Сагсай	18660	31129	41	836	2182	14075	13995
Толбо	35747	43480	7	813	2497	22794	17369
Улаанхус	40764	45732	117	1083	4156	19045	21331
Цэнгэл	65250	84719	124	1760	5171	35817	41847
Өлгий	4315	5563	13	192	1078	1480	2800
Дүн	391826	471727	637	10426	33268	191682	235714

Сумын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2017- 2016
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Зөрүү
Алтай	5.1	0.1	3.0	11.4	50.8	34.6	-5224
Алтанцөгц	3.4	0.3	2.0	5.3	35.2	57.1	-2324
Баяннуур	5.5	0.3	2.4	3.8	27.0	66.5	91
Бугат	5.4	0.0	1.7	5.0	41.2	52.0	6478
Булган	4.3	0.2	2.9	13.1	23.9	59.8	-6002
Буянт	6.2	0.1	1.7	6.7	58.8	32.8	6112
Дэлүүн	18.2	0.0	2.1	7.0	36.7	54.2	34568
Ногооннуур	7.2	0.1	2.0	4.9	28.2	64.7	315
Сагсай	6.6	0.1	2.7	7.0	45.2	45.0	12469
Толбо	9.2	0.0	1.9	5.7	52.4	39.9	7733
Улаанхус	9.7	0.3	2.4	9.1	41.6	46.6	4968
Цэнгэл	18.0	0.1	2.1	6.1	42.3	49.4	19469
Өлгий	1.2	0.2	3.5	19.4	26.6	50.3	1248
Дүн	7.7	0.1	2.2	7.1	40.6	50.0	79901


Төл бойжилт

2017 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 98.6 хувь буюу 902954 толгой эх мал төллөж гарсан төлийн 93.5 хувь буюу 856849 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2016 оныхоос 95174 толгой буюу 10.4 хувиар нэмэгдлээ.

БОЙЖУУЛСАН ТӨЛ, СУМААР, 2017 ОН /мян.то



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР /мян.тол/



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1995	497763	771	15210	33553	281715	166514
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
2004	524505	547	11917	29467	232859	249715
2005	410257	473	9664	24541	203799	171780
2006	521900	508	12240	28166	231710	249076
2007	539265	443	12402	28270	240525	257625
2008	484506	424	9729	23705	234999	215649
2009	413901	487	8656	22460	207360	174938
2010	357520	420	6726	19061	181318	149995
2011	487580	615	11036	26655	204194	245080
2012	489680	642	12575	26600	217323	232540
2013	607272	665	13553	34455	255534	303065
2014	664384	613	15785	41846	288752	317388
2015	781029	726	19625	49506	345737	365435
2016	789819	700	20563	52439	353164	362953
2017	856849	964	23373	56034	394647	381831
%	108.5	137.7	113.7	106.9	111.7	105.2
Зөрүү	67030	264	2810	3595	41483	18878

Гарсан ботгоны 95.4 хувь, унаганы 96.5 хувь, тугалын 97.3 хувь, хурганы 96.9 хувь, ишигний 92.5 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад төлийн бүх төрөл дээр 3595-41483 толгой хүртэл нэмэгдэснийг дээрхи хүснэгтээс харж болно.

Бойжуулсан төлийг сумаар авч үзвэл бүх сумуудад өнгөрсөн оныхоос нэмэгдэж ялангуяа хамгийн ихээр Дэлүүн суманд 10376, Улаанхус суманд 5695, Цэнгэл суманд 4421 толгойгоор тус тус өслөө.

